



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/260

Арвайхээр

**Газар эзэмших эрхийг хүчингүй болгох  
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрчис-ундарга ХХК (6167756)-ийн эзэмшил 12 дугаар баг Үйлдвэрлэлийн бүсийн урд байрлах 750000м<sup>2</sup> газрын, Хашхан ХХК (2603756)-ийн эзэмшил Залуучуудын 1 дүгээр гудамж ерөнхий боловсролын Тэмүүлэл-Эрдэм сургуулийн баруун хойно байрлах нийтийн орон сууцны зориулалттай 1300м<sup>2</sup> газрын эзэмших эрхийг тус тус хүчингүй болгосугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны а/319 дугаар захирамжийн Хашхан ХХК, 2017 оны а/184 дүгээр захирамжийн Эрчис-ундарга ХХК-тай холбогдох заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Газрыг төрийн мэдэлд авч, газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулж, ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100558